МЭДЭЭ · 2026 оны 4-р сарын 13

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ–ХАМТЫН АЖИЛЛАГАА” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Прокурор, цагдаагийн байгууллага хамтран “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” “Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагыг сайжруулах замаар хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг үр дүнтэй хамгаалах, хүний эрхэд суурилсан, хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих хандлагыг төлөвшүүлэх, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Хүүхэд хамгаалал–хамтын ажиллагаа” сэдэвт сургалтыг 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгууллаа.



Сургалтад хүүхэд хохирсон, холбогдсон хэрэгт дагнан хяналт тавих прокурорууд, мөрдөн шалгах ажиллагаа явуулах мөрдөгчид, түүнчлэн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтнууд болох хүүхдийн эрхийн улсын байцаагч, нийгмийн ажилтнууд зэрэг 150 гаруй алба хаагч хамрагджээ.





Сургалтын хүрээнд Бэлгийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэргийн хохирогчоос мэдүүлэг авах ажиллагаанд мөрдөх зарчим, анхаарах асуудал; Хууль ёсны төлөөлөгчийн оролцоотойгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахад баримтлах шаардлага, онцлог; Алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зэрэг сэдвүүдийн хүрээнд онол, практик хосолсон мэдээлэл өгсөн байна.

Мөн эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “Хүүхэд хамгаалал–хамтын ажиллагаа” гарын авлагыг боловсруулж, алба хаагчдад гардууллаа.



Энэхүү сургалт нь холбогдох байгууллагуудын уялдаа холбоог гүнзгийрүүлэх, хамтын ажиллагаа, хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг сайжруулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.





Эх сурвалж: https://prosecutor.mn/post/680